

57

**“ТОГТООЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 04 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаанд оролцсон гишүүд газрын тосны бүтээгдэхүүнд ногдуулах импортын барааны гаалийн албан татвар нь 2026 онд төвлөрөх орлогын хэмжээнд нөлөөлөх эсэх асуудлаар асуулт асууж, хариулт авсан болно. Мөн тогтоолын төсөлд дагаж мөрдөх хугацааг энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс гэж тусгасан нь хууль буцаж үйлчлэх онцгой нөхцөл үүсэх эрсдэлтэй тул уг хугацааг өөрчлөх саналыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар тогтоолын хэрэгжих хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР